



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 09 сарын 24 өдөр

Дугаар 395

Улаанбаатар хот

Хөрөнгө хүлээн авч бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсээс 2021 оны 06/7216 албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу иргэн Д.Батбаярын “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газарт учруулсан хохиролд тооцон нийт 2,220,338,600.00 (хоёр тэрбум хоёр зуун хорин сая гурван зуун гучин найман мянга зургаан зуун) төгрөгийн үнэлгээ бүхий хавсралтад заасан газар, үл хөдлөх хөрөнгийг өмчлөгчийн зөвшөөрлийг үндэслэн төрийн өмчид хүлээн авч “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газарт эзэмшүүлэн, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий захирал Х.Бадамсүрэнд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Газар эзэмших эрх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрх шилжүүлэн авах гэрээг тухайн өмчлөгч, эзэмшигч этгээдтэй байгуулах;

2.2. Холбогдох баримтыг бүрдүүлэн Орхон аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Улсын бүртгэлийн хэлтэст хандаж газар эзэмших эрх, үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын нэр дээр шилжүүлэн бүртгүүлэх;

2.3. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг хүлээн авч бүртгэх, ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах,

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001408

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны ᠑᠘ дүгээр сарын ᠒᠒-ний өдрийн
3᠑5 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИД ХҮЛЭЭН АВЧ "ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ХӨРӨНГӨД
БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

д/д	Үл хөдлөх хөрөнгийн нэр	Гэрчилгээний дугаар	Улсын бүртгэлийн дугаар	Зориулалт	Талбайн хэмжээ /м.кв/	Ашиглалтын хугацаа	Хөрөнгийн үнэлгээ /төгрөг/	Өмчлөгч /эзэмшигч/ этгээдийн нэр	Зөвшөөрөл өгсөн эсэх
1.Биег бус хөрөнгө буюу газар эзэмших эрх									
1	Орхон аймаг Баян-Өндөр сумын 6-р баг, Согоот 6 хороолол, 14 дүгээр сургуулийн баруун урд байрлах худалдаа, нийтийн үйлчилгээний зориулалттай газар	000024706	Э-2101002041	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	228	15 жил /2010.06.09-ны өдрийн 245 тоот/	1,858,631,900.00	"Умбайн шим" ХХК	"Умбайн шим" ХХК-ийн 2021 оны 06 сарын 10-ны өдрийн №4 тоот хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр, албан хүсэлт ирүүлж зөвшөөрсөн.
2.Барилга, байгууламж									
д/д	Үл хөдлөх эд хөрөнгийн нэр	Гэрчилгээний дугаар	Улсын бүртгэлийн дугаар	Зориулалт	Талбайн хэмжээ, м.кв	Давхар, өрөөний тоо	1,858,631,900.00	Өмчлөгч /эзэмшигч/ этгээдийн нэр	Зөвшөөрөл өгсөн эсэх
1	Орхон аймаг Баян-Өндөр сумын 6-р баг, Согоот 6 хороолол, 14 дүгээр сургууль гудамж 14 байр баруун урд зоорийн, 1 давхар тоот хаягт байршилтай	000878187	Ү-2101024615	Үйлчилгээ, оффис	456	Зоорийн, 1 давхар, 3 өрөө		"Умбайн шим" ХХК	"Умбайн шим" ХХК-ийн 2021 оны 06 сарын 10-ны өдрийн №4 тоот хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр, албан хүсэлт ирүүлж зөвшөөрсөн.
2	Орхон аймаг Баян-Өндөр сумын 6-р баг, Согоот 6 хороолол, 14 дүгээр сургууль гудамж гүний худгийн замын урд байр баруун урд 2, 3, 4 давхар тоот хаягт байршилтай	000878197	Ү-2101024620	Үйлчилгээ, оффис	684	3 давхар 16 өрөө		"Умбайн шим" ХХК	"Умбайн шим" ХХК-ийн 2021 оны 06 сарын 10-ны өдрийн №4 тоот хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр, албан хүсэлт ирүүлж зөвшөөрсөн.

д/д	Үл хөдлөх хөрөнгийн нэр	Гэрчилгээний дугаар	Улсын бүртгэлийн дугаар	Зориулалт	Талбайн хэмжээ /м.кв/	Ашиглалтын хугацаа	Хөрөнгийн үнэлгээ /төгрөг/	Өмчлөгч /эзэмшигч/ этгээдийн нэр	Зөвшөөрөл өгсөн эсэх
-----	-------------------------	---------------------	-------------------------	-----------	-----------------------	--------------------	----------------------------	----------------------------------	----------------------

1.Биет бус хөрөнгө буюу газар эзэмших эрх

3	"Эрдэнэт хивс" ХХК-ийн ноосны агуулахын залгаа хойд талд байрлах агуулахын зориулалттай газар	000141461	Э-2101002165	Агуулах	567	15 жил /2010.03.24-ны өдрийн 102 тоот/			
	2.Барилга, байгууламж								
д/д	Үл хөдлөх эд хөрөнгийн нэр	Гэрчилгээний дугаар	Улсын бүртгэлийн дугаар	Зориулалт	Талбайн хэмжээ, м.кв	Давхар, ерөөний тоо	361,706,700.00	Мөнхнаст Энхзаяа РД: 3В66041710	Иргэн М.Энхзаяа 2021 оны 06 сарын 14-ны өдөр албан хүсэлт ирүүлж зөвшөөрсөн.
4	Орхон аймаг Баян-Өндөр сумын 14-р баг, Говил МБҮйлдвэрийн хашаанд тоот хаягт байршилтай агуулахын зориулалттай газар	000878200	Ү-2101001016	Агуулах	472	2 давхар			
							2,220,338,600.00		
	НИЙТ ҮНЭ							(хоёр тэрбум хоёр зуун хорин сая гурван зуун гучин найман мянга зургаан зуу)	